



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар АМ36

Алтай хот

Аймгийн хөдөлмөр, нийгмийн  
түншлэлийн гурван талт хороог шинэчлэн  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 01 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралтаар баталсан "Салбар хороо болон аймаг, нийслэлийн хорооны дүрэм"-ийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)  
Дэд дарга: Л.Сумаахүү (аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)  
Гишүүд: С.Мөнжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)  
Г.Оюунчимэг (аймгийн Ажил олгогч эздийн холбооны дэд дарга)  
Р.Санжжав ("Баян таян" ХХК-ийн захирал)  
Г.Жалцавжий (Аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимын тэргүүлэгч)  
Б.Ундармаа (Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч гишүүн, АУС-ийн ҮЭХ-ны дарга)  
Б.Мягмардаш (аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч гишүүн, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ҮЭХ-ны дарга)

Нарийн бичгийн дарга: Ш.Жаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Үндэсний хорооноос баталсан дүрмийг баримтлан ажиллахыг аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо (Г.Чинбат)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201000502